

**АЖИЛЧДЫН НОРМЫН ХУВЦАС, ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ,  
ТАВИГДАХ ШААРДЛАГА**

<b>№</b>	<b>Хувцас хэрэглэлийн нэр</b>	<b>Тоо хэмжээ</b>	<b>Хэмжих нэгж</b>
<b>БАГЦ1-Ажлын хувцас</b>			
1	Зуны ажлын цамц, мөрөвчтэй өмд (хослол)	192	Ширхэг
2	Өвлийн ажлын хүрэм, мөрөвчтэй өмд (хослол)	140	Ширхэг
3	Тосны комбинзон	50	Ширхэг
4	Ажлын бодино ханцуйтай цамц поло	350	Ширхэг
5	Ажлын бодино ханцуйтай цамц сорочка	350	Ширхэг
6	Ажлын хантааз	350	Ширхэг
7	Жолооч малгай	350	Ширхэг
<b>БАГЦ2-Ажлын гутал</b>			
1	Гутал	192	Ширхэг

<b>ЕРӨНХИЙ ШААРДЛАГА</b>	
<b>“Ажилчдын нормын хувцас, хэрэгсэл”-ийн ерөнхий шаардлага нь MNS13688:2000 Монгол улсын стандартыг хангасан байна.</b>	
1)	Тендерт оролцогч нь тендерийн материал хүлээн авах хугацаанд техникийн тодорхойлолтод дурдсан бараанаас 1 ширхгийт өгнө.
2)	Тендерийн баримт бичигт заасан тооны хувцасны чанар нь захиалагчид анх ирүүлсэн загварын хувцаснаас материал, чанар (гараар мэдрэхэд ялгаагүй), хийцийн хувьд ялгаагүй, өнгө зөрүүгүй байна. Ялгаа гарсан тохиолдолд захиалагч ирүүлсэн хувцсыг бүгдийг гүйцэтгэгчид бөөнөөр буцааж, тендерийн бичиг баримтад заасан, шаардлага хангасан хувцсаар солиулна.
3)	Хувцас хэрэгсэлд орсон материал нь хүний биед харшил үүсгэх, арьс салстыг цочроох үйлчлэлгүй, биеийн хөлстэй урвалд орох чанаргүй, мөн шатахад барьж наалддаггүй байх ба зориулалтын хувцасны материал байна.
4)	Материал нь мэргэжлийн байгууллагын сертификат, тодорхойлолт (дүгнэлт), шинжилгээний бичиг зэрэг дагалдах баримт бичигтэй байна.
5)	Хөлөргөж чийг татахаас сэргийлсэн агаар сэлгэлт сайтай, амьсгалдаг материал эсвэл технологи ашигласан байна.
6)	Ажлын хувцасны бүх оёдлыг 1 см-т 4-5, дотор холбох, хавсарсан оёдлыг 1см-т 3-4 хатгацтайгаар, сайн чанарын 100% даавуун утсаар оёно. Залгаас болгоныг бат бөх байлгах үүднээс давхар оёдол хийж өгсөн байна.
7)	Ажлын хувцас бүр (Ажлын нимгэн бодино ханцуйтай цамц поло, Ажлын бодино ханцуйтай цамц сорочка хамаарахгүй) гэрэл ойлгогч цацуулагчтай оёсон байна.
8)	Угаалгын градус $+30^{\circ}\text{C}$ -аас $+60^{\circ}\text{C}$ -д угааж, $+60^{\circ}\text{C}$ -аас $+71^{\circ}\text{C}$ -д хатаахад өнгө болон материалын агшилт суналт доорх шаардлагыг хангасан байна.
9)	Угаалга цэвэрлэгээний дараа агшиж (агшилт суналт нь анхны хэмжээний 5 %-иас ихгүй) сунахгүй буюу өмсгэлийн анхны хэмжээ болон хувцасны өнгө өөрчлөгдөхгүй байна. (Угаалтаар агшиж, сунасан тохиолдолд ажлын хувцсыг бүгдийг солино).
10)	Ажлын хувцсанд угаалга, арчилгааны шошго, хувцасны хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, арчилгааны заавар болон хувийн дугаар, бусад шаардлагатай мэдээллийг хувцас тус бүрт оёж тогтоосон байна.
11)	Ажлын хувцас тус бүр дугаарлалын тэмдэглэгээ бүхий давтагдахгүй хувийн дугаартай байна.
12)	Ажлын хувцас нь эрэгтэй, эмэгтэй загвартай байна. Биеийн анатоми хэлбэрт тохирсон байна.
13)	Эрэгтэй 48, 50, 52, 54, 56, 58, 60, 62, 64 ; Эмэгтэй 42, 44, 46, 48, 50, 52, 54 гэсэн хэмжээтэй байх ба том размерыг захиалгаар хэмжээс авч үйлдвэрлэнэ.
14)	Захиалагчид нийлүүлэх бараа нь үйлдвэрлэлийн болон механик ямар нэгэн гэмтэл согоггүй, заасан өнгөнөөс зөрөөгүй байна.
15)	Захиалагчийн тендерийн бичиг баримтад заасан барааны чанар стандартын үзүүлэлтээс давсан, илүү сайн чанар, үзүүлэлттэй байвал давуу тал болно.

## 1. Зуны ажлын цамц, мөрөвчтэй өмд (хослол)

Барааны нэр:	1. Зуны ажлын цамц, мөрөвчтэй өмд (хослол) Техникийн тодорхойлолт
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна..
Үзүүлэлт, шаардлагууд	<p>1. <b>Цамц:</b> Хувцас бүрт цацуулагч буюу гэрэл ойлгогч хийсэн байна.</p> <p>2. Хөдөлгөөн хийх үед гар чөлөөтэй хөдлөх нөхцөлийг хангах зорилгоор арын гол хэсэгт нугалаас оруулж оёх.</p> <p>3. Цамцыг суурьтай хэвтээ захтай хийх. Товчилсон үед хөдөлгөөний болон амьсгалах чөлөөт байдлыг хангасан байх.</p> <p>4. Ханцуйны хагалбар 18-20 см байх ба товчтой хийнэ.</p> <p>5. Цамцны уртыг тонгойх үед нуруу ил гарахааргүй буюу ташаан толгой давсан урт байхаар хийнэ.</p> <p>6. Ар болон урд талын цээж хэсэг, бүсэлхий болон ханцуин тойрог хэсэгт хөндлөн гэрэл ойлгогч оёно. Гэрэл ойлгогчны өргөн 3-4 см байна.</p> <p>7. Ханцуин тохой хэсэгт элэгдэлээс хамгаалж, өнгө материалыг давхарлан тохойвч ширж оёсон байх.</p>
	<p>8. Цамцны баруун энгэрийн дээд талд 2 талдаа кноп бүхий тагтай ил халаастай байна. Зүүн энгэрийн халаасанд бал, үзэгний нэмэлт таславч оёж өгсөн байна. 0,5мм ил оёдлоор давхар оёсон байх. Халаасны тагийг товчтой хийнэ.</p> <p>9. Цамцны урд хэсэг далд товчилгоотой, товчтой байна.</p> <p>10. Ханцуин манжетканы өргөн 5 см байна.</p> <p>11. Цамцны энгэрийн ил халаас нь хэмжээ 12-14 см х 14-16 см, тагны өргөн 5-7 см, товчлогддог байна. (цамцны харьцаанд тааруулан хийх)</p> <p>12. <b>Өмд:</b> Мөрөвчтэй өмдний ташаа хэсэгт ил дарж оёсан ташуу халаастай ба 2 гуяны хажуу талд хөндийрүүлэгчтэй ил халаастай байна. Ил халаасны таг кнопон товчилгоотой. Хэмжээ: 18x18см, хөндийрүүлэгчийн өргөн 2,5см</p> <p>13. Мөрөвчтэй өмдны арын суудал, өвдөг элэгдлээс хамгаалсан давхарлагага ширээстэй хийгдсэн байна.</p> <p>14. Өмдний шилбэ болон энгэрийн халаасны ирмэг дагуу хэсэгт гэрэл ойлгогч туузтай (5см) байна.</p> <p>15. Өмдны бус хэсэгт түдүүл хийх ба бусний арын хэсэгт резинтэй хийнэ.</p> <p>16. Шуумаг хэт өргөн биш шулуун загвартай байна</p> <p>17. Өмдний ерөнхий хэлбэр сул чөлөөтэй, босох суух, том алхах зэрэгт салтаа болон бусад хэсгээр таталдаад байхааргүй, хөдөлгөөний чөлөөт байдлыг хангасан сул хэлбэртэй байна.</p> <p>18. Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг (нэхээс) зөв байна.</p> <p>19. Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд биед эвтэйхэн байна.</p> <p>20. Компанийн таних тэмдэг, логоо нь цамцны зүүн талын ханцуин булчин хэсэгт байрлана. 7x7 см хэмжээтэй байна.</p> <p>21. Цамцны бүх оёдлы 0,2-0,5 см ил оёдлоор дарж оёсон байх. Цамцны хормой болон өмдний шуумаг хэсгийг 2,5 см нугалж ил оёсон байна.</p>
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодлтой байна.
Материалын холио, өнгөний код	<p>Хүрэм, өмд (хослол)- 60% полистер, 40% хөвөн даавуу байна.</p> <p><b>Өнгө:</b> <b>Их бие – Хар хөх</b></p> 

	<p><b>Цамцны цээж болон ханцууйн дээд хэсгийн оруулга- Үндсэн цэнхэр</b></p>  <p><b>Гэрэл цацруулагч – Саарал</b></p> 
Ерөнхий зураг	 

## 2.Өвлийн ажлын хүрэм, өмд (хослол)

Барааны нэр:	Өвлийн ажлын хүрэм (хослол)
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.
=	<p><b>Хүрэм:</b>Өвлийн улиралд өмсөх хувцас нь -25°C - 35°C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна.</p> <p>1. Цацуулагч буюу гэрэл ойлгогч нь 5 см-ийн өргөнтэй, цайвар саарал өнгөтэй байна. (өрөнхий зургийн дагуу)</p> <p>2. Хүрэм нь өгзөг давсан урттай байх ба хөдөлгөөний чөлөөт байдлыг хангасан сул хэлбэртэй байна. Юудэн нь сойлттой, салдаг кноптой байна. (өрөнхий зургийн дагуу)</p> <p>3. Хүрэм нь босоо захтай байх ба хөдөлгөөний болон амьсгалын чөлөөт байдлыг хангасан байх.</p> <p>4. Хүрэмний бүсэлхийн дотор талд салхи орохоос хамгаалсан дотор хормой бүхий резинэн манжеттай бүстэй байна.</p> <p>5. Хүрэмний урд талын доод хэсэгт 2ш ил халаастай. Халаасны хэмжээ 22x19 см. Халаасыг хөндийрүүлэгчтэй хийнэ. Хөндийрүүлэгчийн өргөн 2,5 см байна.</p> <p>6. Хүрэмний урд талын гол хэсэгт 2ш ил халаастай. Халаасыг хөндийрүүлэгчтэй хийнэ. Хөндийрүүлэгчийн өргөн 2,5 см байна.</p> <p>7. Халаасны таг зангуун товчилгоотой байна.</p> <p>8. Хүрэмний ханцуйн үзүүрийн дотор талд салхинаас хамгаалсан дотортой байх ба сүлжмэл ханцуй давхар хийсэн байна. Сүлжмэл ханцуйн өргөн 7 см байна.</p> <p>9. Хүрэмний урд товчилгоог цахилгаантай хийх ба цахилгааныг дарсан хаалтыг зангуун товчилгоотой хийнэ. /Сайн чанарын цахилгаан болон зангуу сонгож хийх./</p> <p>10. <b>Өмд:</b> Мөрөвчтэй өмд нь сул хэлбэртэй. Цээжин хэсгээр мөн адил дулаалгын материалтай. Урд талын гол хэсэгт цахилгаан товчилгоотой байна. Цахилгаан товчийг дарсан хаалт нь зангуун товчилгоотой байна.</p> <p>11. Өмдний энгэр хэсэгт цахилгаантай босоо халаастай. /Гар утас болон бусад зүйлс хийх тохиромжтой байна./ Ташаа хэсэгт ташуу халаастай, гуяны хажуу талд тагтай ил халаастай. Ил халаасыг хөндийрүүлэгчтэй хийнэ. Хөндийрүүлэгчний өргөн 2,5 см байна. Ил халаасны хэмжээ:18x18см байна.</p> <p>12. Өмдний арын суудал болон өвдөг хэсэгт элэгдлээс хамгаалсан давхарлагаатай хийгдсэн байна. Давхарлагааг ширж оёсон байна.</p> <p>13. Өмдний шилбэ, гуя, бүсэлхий, энгэрийн дээд ирмэг болон нуруу хэсэгт гэрэл ойлгогч туузыг (5см) оёсон байна.</p>
	<p>14. Өмдний шуумаг хэсэгт, шуумагны өргөн нарийнийг тохируулах зориулалттай сойгч оёсон байна. Зангуун товчилгоотой.</p> <p>15. Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг /нэхээс/ зөв байна.</p> <p>16. Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэйхэн байна.</p> <p>17. Компанийн таних тэмдэг, логоог мөрөвчтэй өмдний энгэрийн зүүн талд хадсан байх ба хүрэмний зүүн талын ханцуйн булчин хэсэгт тус тус байрлуулж оёсон байна. Логоны хэмжээ 7x7 см хэмжээтэй байна.</p>
Материалын холио, өнгөний код	<p>Өвлийн хүрэм, өмд (хослол) — Гадна материал: 38-42% полистер, 58-62% хөвөн даавуу</p> <p>Дотор материал: 100% хөвөн даавуу /дулаалгын материал/ байх бөгөөд зөвхөн ар нуруу, цээж, суганы хэсэгт хөлрөхөөс хамгаалсан дотортой байна.</p> <p><b>Өнгө:</b></p>

	<p><b>Их бие – Хар хөх</b></p>  <p><b>Цамцны цээж болон ханцууйн дээд х02,,,,,,,,,,н оруулга- Үндсэн цэнхэр</b></p>  <p><b>Гэрэл цацруулагч – Саарал</b></p> 
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна.
Ерөнхий зураг	 

### 3. Тосны комбинзон


Барааны нэр:	<b>3. Тосны комбинзон</b>
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	<p>Хүний биесийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.</p>
Үзүүлэлт, шаардлагууд	<ol style="list-style-type: none"> <li>Өвлүйн улиралд өмсөх хувцас нь -25°C - 35°C хүртэлх температурт өмсөхөөр зориулагдсан байна.</li> <li>Цацруулагч буюу гэрэл ойлгогч нь 5 см-ийн өргөнтэй, цайвар саарал өнгөтэй байна. (ерөнхий зургийн дагуу)</li> <li>Юудэнтэй байна. Юудэнгийн ирмэгээр чангаль, суллах зориулалт бүхий утас гүйлгэж оёсон байна.</li> <li>Комбинезоны бүсэлхийн дотор талд чангаль суллахад зориулан уяа шургуулж оёсон байна.</li> <li>Цамцны далны хэсгийн оруулганы дотор хэсэгт торон салхивчтай оёх. Оруулгын доод ирмэг задгай байх ба ирмэг хэсэгт 2-3 удаа бөхөлгөө хийсэн байх</li> <li>Ханцуйн үзүүр хэсэгт резин оёсон байна.</li> <li>Комбинзон нь үргэлж эсгэлттэй, ажлын хувцас дээр давхар өмсөхөд тохиромжтой, суух, тонгойх зэрэг хөдөлгөөний чөлөөт байдлыг хангасан сул загвартай байна.</li> <li>Комбинзоны урд энгэр цахилгаантай, цахилгаанаа дарсан кноп бүхий хаалттай байна. Кноп болон цахилгаан нь угаалгад тэсвэртэй, чанар сайтай материалыар хийгдсэн байна.</li> </ol>
Материалын холио, өнгөний код	<ol style="list-style-type: none"> <li>Комбинзоны арын суудал, өвдөг, тохой хэсэгт элэгдлээс хамгаалсан давхарлагаатай хийгдсэн байна. Давхарлагааг ширж оёсон байх.</li> <li>Комбинзоны шилбэний тойрог, бүсэлхийн тойрог, цээж, ханцуйн тойрог, малгайн гол хэсэгт гэрэл ойлгогч туузыг (5см) оёсон байна.</li> <li>Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг /нэхээс/ зөв байна.</li> <li>Өнгө үзэмжтэй, хөнгөн, өмсөхөд эвтэйхэн байна.</li> <li>Компанийн таних тэмдэг, логог зүүн ханцуйн булчин хэсэгт байрлуулан оёсон байна. 7x7 см хэмжээтэй байна.</li> </ol> <p>Комбинzon — Гадна материал: 38-42% полистер, 58-62% хөвөн даавуу  Дотор материал: 100% хөвөн даавуу /дулаалгын материал/ байх бөгөөд зөвхөн ар нуруу, цээж, суганы хэсэгт хөлрөхөөс хамгаалсан дотортой байна. Тосны шингэц удаан байх “бризэнт” -тэй дүйцэх материалтай байна.</p> <p><b>Өнгө:</b>  <b>Их бие - Хар хөх</b>  </p> <p><b>Гэрэл цацруулагч – Саарал</b>  </p>
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна.
Ерөнхий зураг	



#### 4.Ажлын богино ханцуйтай цамц поло

Барааны нэр:	4.Ажлын богино ханцуйтай цамц поло
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биенеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.
Үзүүлэлт, шаардлагууд	<p>1. Сул хэлбэртэй. Зах болон ханцуйн үзүүр хэсэг сүлжмэл манжеттай. Ханцуйн манжетны өргөн 2см байна. Богино ханцуйтай.</p> <p>2. Энгэр хэсэгт хагас товчилгоотой. Хэвтээ захтай.</p> <p>3. Энгэрийн зүүн талд ил халаастай</p> <p>4. Поло цамцны урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна. /Өмдөн дотор хийж өмсөхөд тохиромжтой урттай байх./</p> <p>5. Компанийн таних тэмдэг, лого зүүн ханцуйнд байрлана. 7x7 см хэмжээтэй байна.</p>
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодлой байна.
Материалын холио, өнгөний код	Нимгэн цамц поло – 35% полистер, 65% хөвөн даавуу (бага зэрэг зузаан) – угаалтаар агшдаггүй сайн чанарын материал байх. <b>Өнгө:</b> Цагаан
Ерөнхий зураг	<p>Эрэгтэй поло цамц</p>

## 5.Ажлын богино ханцуйтай цамц сорочка

Барааны нэр:	<b>4.Ажлын богино ханцуйтай сорочка цамц</b>
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.
Үзүүлэлт, шаардлагууд	<ol style="list-style-type: none"> <li>Сул бэлбэртэй. Арын далны хэсэгт оруулгатай ба хөдөлгөөний чөлөөт бадлыг хангах зорилгоор оруулганы гол хэсэгт арын доод хэсгийг нугалж оёсон байна.</li> <li>Богино ханцуйтай. Ханцуйн үзүүрийг 2,5 см- ээр нугалж оёсон байна.</li> <li>Энгэрийн хэсэг товчилгоотой.</li> <li>Сорочка цамцны урт нь нуруу ил гарахааргүй ташаан толгой давсан байна. / Өмдний дотор талд хийж өмсөхөд тохиромжтой байх./</li> <li>Компанийн таних тэмдэг, лого зүүн ханцуйнд байрлана. 7x7 см хэмжээтэй байна.</li> <li>Энгэрийн зүүн талд ил халаастай.</li> </ol>
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна.
Материалын холио, өнгөний код	Нимгэн даавуун сорочка цамц – 35% полистер, 65% хөвөн даавуу– угаалтаар агшдаггүй сайн чанарын материал байх. <b>Өнгө:</b> Цагаан
Ерөнхий зураг	

## 6.Ажлын хантааз

Барааны нэр:	<b>6.Ажлын хантааз</b>
<b>Техникийн тодорхойлолт</b>	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, будаг гардаггүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.
Үзүүлэлт, шаардлагууд	<ol style="list-style-type: none"> <li>Хантааз нь цахилгаантай задгай энгэртэй, цээж хэсэгт торон оруулгатай.. Цахилгаан нь бат бөх байх ба угаалгад тэсвэртэй материалыар хийгдсэн байна.</li> <li>Хантаазны хоолойн ухлаадас V хэлбэртэй байна. Хоолойн болон ханцуйн ухлаадсыг эмжих оёсон байна.</li> <li>Гэрэл ойлгогч нь 5 см өргөнтэй байна. Цээж, бүсэлхий, мөр, бүсэлхийн сойгч хэсэгт гэрэл цацууллагч хадсан байна. Ерөнхий зургийн дагуу.</li> <li>Энгэрийн доод хэсэгт 2ш тагтай, ил халаастай. Таг нь зангуун товчилгоотой.</li> <li>Баруун энгэрт 13x15см-ээс багагүй хөндийрүүлэгчтэй халаастай, халаасанд бал, үзэгний нэмэлт таславч оёж өгсөн байна. Зүүн энгэрт Лого хадах оруулга хэсэг дээр лого хадсан байна.</li> <li>Хантаазны хажуу хэсэгт чангалж, хантаазны өргөн нарийнийг тохируулах зориулалттай сойгч байна. Зангуун товчилгоотой.</li> </ol>

	<p>7. Хос эд ангийн хэмжээ, байрлал нь адил хэмжээтэй, материалын үндсэн утасны чиг (нэхээс) үлгэрт зөв байна.</p> <p>8. Компанийн таних тэмдэг, лого зүүн энгэрт байрлана. 7x7 см хэмжээтэй байна.</p>
Материалын холио, өнгөний код	<p>Ажлын хантааз - Гадна материал: 63-67% полистер, 33-37% хөвөн даавуу Дотор материал: 100% хөвөн даавуу</p> <p><b>Өнгө:</b> <b>Их бие – Улаан</b></p>  <p><b>Гэрэл цацуулагч – Саарал</b></p> 
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодлтой байна.
Ерөнхий зураг	

## 7. Жолооч малгай

Барааны нэр:	7. Жолооч малгай
Техникийн тодорхойлолт	
Эрүүл ахуй, аюулгүйн байдал	Хүний биеийг гадны таагүй нөлөөнөөс бүрэн хамгаалах бөгөөд эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэгтүй, будаг гардагтүй, эдэлгээний явцад өнгөн хэсэгт бүрзийлт үүсдэггүй, гадны механик үйлчлэлд тэсвэртэй, шатамхай биш байна.
Үзүүлэлт, шаардлагууд	<ol style="list-style-type: none"> <li>Жолооч малгай нь жижиг саравчтай (2-3 см) бат бөх байх ба угаалгад тэсвэртэй материалаар хийгдсэн байна.</li> <li>Хөлс нэвтрүүлдэг байна.</li> <li>Агаар солилцдог байна.</li> <li>Компанийн таних тэмдэг, логог урд хэсэгт оёж хийнэ.</li> </ol>
Материалын холио, өнгөний код	Жолооч малгай - Гадна материал: 63-67% полистер, 33-37% хөвөн даавуу Дотор материал: 100% хөвөн даавуу <b>Хар өнгөтэй байна.</b>
Баглаа боодол	Тээвэрлэхэд тохиромжтой, ус чийг, гадны нөлөө, механик гэмтлээс хамгаалах зориулалтын сав, баглаа боодолтой байна.
Ерөнхий зураг	<p style="text-align: center;"><b>Жолооч малгай</b></p> 

### Өвлийн ажлын гуталд тавигдах шаардлага:

- Барааны тодорхойлолт: Ажлын өвлийн гутал нь бохирдол, механик нөлөөлөл, хүйтэн температур зэрэг үйлдвэрлэлийн гэмтэл болон хүрээлэн буй орчны тааламжгүй хүчин зүйлээс хамгаалах зориулалттай байна.

### Техникийн шаардлага:

Хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй.

- Өвлийн гутал нь -300С-ээс -400С хүртэлх температурт өмсөхөд зориулагдсан, арьсан материалтай, хөлддөггүй, нэхий дотортой байна.
- Хуруу, шагайн хамгаалалттай, 200 Дж хүртлэх хэмжээний цохилтын хүчийг даах тэсвэртэй.
- Тос, ус чийг, тоос шороо, химийн бодис болон шүлтлэг орчинд ажиллахад тэсвэртэй, чийг татдаггүй, цахилгаан дамжуулдаггүй, бат бөх хийцтэй байх.
- Зузаан, халтирахгүй, хөлддөггүй ултай байх.
- Хөдөлгөөнд саадгүй түрийн зохион байгуулалттай байх
- Гутал нь шагай дарсан хагас түрийтэй байна.

### Ажлын гуталны өнгө, хэмжээ:

Ажлын өвлийн гутал нь хар, хар саарал өнгөтэй байна. Гутлын хэмжээ, өнгийг гэрээнд тусгасны дагуу гүйцэтгэнэ.

2. Стандарт: Өвлийн ажлын гутал нь “Хөлний хамгаалалт, ажлын тусгай гутал” MNS 5623:2006 стандартын шаардлагыг хангасан байна.
3. Баглаа, боодол: Ус чийг, тоос шороо нэвтрэх, хэлбэр алдагдахаас хамгаалсан зориулалтын савлагаатай байх ба бараа тус бүрийн савлагааны гадна талд гуталны хэмжээг харагдахуйцаар тэмдэглэсэн байна.

-----oOo-----